

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМЫН ГИШҮҮНЧЛЭЛИЙН ЖУРАМ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1 Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим /цаашид “МҮХАҮТ” гэх/-ын гишүүнчлэлийн ангилал, гишүүний эрх, үүрэг, оролцоо, гишүүнчлэлийн хураамж болон бусад асуудалтай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмыг мөрдлөг болгоно.
- 1.2 МҮХАҮТ-ын гишүүн гэдэг нь танхимын дүрмийг хүлээн зөвшөөрч сайн дурын үндсэн дээр элссэн, холбогдох хуулийн дагуу байгуулагдсан дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэн байна. Үндэсний танхимд гишүүнчлэлийн хураамжаа төлдөг аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг Үндэсний танхимын гишүүн, салбар танхимд гишүүнчлэлийн хураамжаа төлдөг аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг салбар танхимын гишүүн гэнэ.
- 1.3 МҮХАҮТ-ын эрхэм зорилго, зорилт, алсын хараа, үнэт зүйлс, дүрэм, журмыг хүлээн зөвшөөрч гишүүн болох хүсэлтэй аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүн сайн дурын үндсэн дээр гишүүнээр элсэх ба гишүүнчлэлийн 5 ангиллаас сонгон ГИШҮҮН болно.

ХОЁР. ГИШҮҮНЧЛЭЛИЙН АНГИЛАЛ, ХУРААМЖ

- 2.1 МҮХАҮТ-ын гишүүнчлэл нь дараах 5 ангилал, нэг жилийн баталгаажуулалтын хураамжтай байна. Үүнд:
 - Standart - 100,000 /нэг зуун мянга/ төгрөг
 - Gold - 500,000 /таван зуун мянга/ төгрөг
 - Platinum - 1,000,000 /нэг сая/ төгрөг
 - Diamond - 3,000,000 /гурван сая/ төгрөг
 - Sponsor - 10,000,000 /арван сая/ төгрөг болон түүнээс дээш;
- 2.2 Гадаадын аж ахуй нэгж, байгууллага гишүүнчлэлээр элсэх бол Diamond эсхүл Sponsor ангиллаас сонголт хийж гишүүнээр элсэнэ.
- 2.3 Гишүүнчлэлийн хураамж нь МҮХАҮТ-ын санхүүжилтийн үндсэн эх үүсвэр байх ба Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын тухай хууль, МҮХАҮТ-ын дүрэмд заасан зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд зориулагдана.
- 2.4 Гишүүнчлэлийн хураамж нь гишүүнчлэлийн ангиллаас хамааран харилцан ялгаатай хөнгөлөлт урамшуулал эдлэх зарчимд үндэслэх ба журмын хавсралт №1-т заасанчлан нарийвчлан зохицуулна.

ГУРАВ. ГИШҮҮНЭЭР ЭЛСЭХ, БҮРТГЭХ

- 3.1 Гишүүний бүртгэл, мэдээлэл, гишүүнчлэлтэй холбоотой асуудлыг Салбар танхим, гишүүнчлэлийн алба (77277070-2) хариуцна.
- 3.2 Гишүүнээр элсэх хүсэлтээ цахимаар илгээнэ. Үүнд:
 - МҮХАҮТ-ын www.mongolchamber.mn цахим хуудасны Гишүүнчлэл цэсэд байрших бүтээгдэхүүн үйлчилгээ болон ангиллаас хамаарсан хөнгөлөлт, гишүүний давуу талын мэдээлэлтэй танилцах;
 - Гишүүнчлэлийн ангиллаа сонгох;
 - Анкетаа асуулгын дагуу бүрэн бөглөж илгээх;
 - Илгээх товч дармагц таны сонгосон ангиллын дагуу нэг жилийн хураамжийн нэхэмжлэх системээс үүсэх тул цахим шуудангаа шалгаж, нэхэмжлэх хүлээн авах;
 - Хураамжийг нэхэмжлэх дээрх Гишүүнчлэл гэсэн дансанд шилжүүлэх;
 - Гүйлгээний утга дээрээ нэхэмжлэх дээрх 10 оронтой дугаарыг бичих;
- 3.3 Хураамжаа бүрэн төлснөөр гишүүнчлэлийн эрх баталгаажна.

- 3.4 Гадаадад үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж гишүүнээр элсэхдээ анкетыг Монгол хэл дээр бөглөн илгээнэ.
- 3.5 Гишүүн аж ахуйн нэгж байгууллагын захирал болон танхимтай хамтран ажиллах ажилтнуудын хувийн мэдээллийг зөвхөн МҮХАҮТ-ын дотоод хэрэгцээнд ашиглана.
- 3.6 Гишүүн байгууллагын бүртгэл, мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд Салбар танхим, гишүүнчлэлийн албанд мэдэгдэн тухай бүр мэдээллээ шинэчилнэ.

ДӨРӨВ. ГИШҮҮНИЙ ЭРХ

- 4.1 Үндэсний танхимын Их хуралд оролцох, Их хурлаар хэлэлцэж буй асуудлаар санал бодлоо илэрхийлэх, Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлд нэрээ дэвшүүлэх, сонгох, сонгогдох;
- 4.2 Бизнесийн орчин дахь хүнд суртал, дарамт шахалт, бизнест учирч буй хүндрэл бэрхшээлийг холбогдох байгууллагад хүргэж шийдвэрлүүлэхийн тулд МҮХАҮТ-аар дамжуулан дуу хоолойгоо илэрхийлэх, бодлогын өмгөөлөл авах;
- 4.3 Үндэсний болон салбар танхимд санал, хүсэлт, гомдлыг цахим болон бичгээр гаргах, шийдвэрлүүлэх;
- 4.4 Гишүүнчлэлийн гэрчилгээ авах;
- 4.5 Өөрсдийн эрх ашиг, сонирхол, бизнесийн салбар, орон нутгийн харьяалал болон бусад байдлаар зөвлөл, хороо, дэд хороо болон зохион байгуулагдаж Танхимын үйл ажиллагаанд оролцох;
- 4.6 Гишүүнчлэлийн ангиллаас хамаарч хөнгөлөлттэй үйлчилгээ авах;
- 4.7 Танхимын www.trademongolia.mn цахим хуудас болон аппликэйшинд ангиллаас хамаарсан эрхээр бүтээгдэхүүн үйлчилгээгээ, мэдээ мэдээлэл, бизнес саналаа байршуулах;
- 4.8 Бүртгэлтэй цахим шуудан болон танхимын вэбсайт, олон нийтийн сүлжээ, бусад мэдээллийн хэрэгслээр дамжуулж өдөр тутмын мэдээ мэдээлэл авах;
- 4.9 Олон улсын болон дотоодод хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрт хамрагдах;
- 4.10 Зохион байгуулагдаж буй төрөл бүрийн арга хэмжээнд оролцох, байр сууриа илэрхийлэх;
- 4.11 Өрсөлдөх чадвараа нэмэгдүүлж төрөл бүрийн шалгаруулалтад ангиллаас хамаарч оролцох, танхимын нэрэмжит шагналаар шагнуулах;
- 4.12 Гишүүн байгууллага нь ангиллаа өөрчлөх эрхтэй.
- 4.13 Гишүүн байгууллага нь МҮХАҮТ-ын дүрмийн 4.3.1 дэх заалтын дагуу гишүүнчлэлээс татгалзах эрхтэй.

ТАВ. ГИШҮҮНИЙ ҮҮРЭГ

- 5.1 Гишүүнчлэл нь элссэнээс хойш нэг жилийн хугацаанд хүчинтэй байх ба хугацаа дуусмагц сунгалтаа хийнэ.
- 5.2 Танхимын нэр, лого болон баталгаажуулах баримт бичиг, брэндингийг буруугаар ашиглахгүй байх;
- 5.3 ХАҮТ-ын тухай хууль болон МҮХАҮТ-ын дүрмийг чанд сахин биелүүлэх;
- 5.4 Үндэсний болон салбар танхимын үүрэг, зорилтыг хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцох;
- 5.5 Шударга өрсөлдөөнийг эрхэмлэх;
- 5.6 Бизнесийн ёс зүйг чандлан сахих;
- 5.7 Танхимын шийдвэр, уриалгыг хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцох;
- 5.8 Танхимаас зохион байгуулж буй бүхий л үйл ажиллагаа, арга хэмжээ, үзэсгэлэн, сургалт, семинар, өдөрлөг, шалгаруулалт, судалгааны ажилд идэвх, санаачилгатай оролцох;
- 5.9 Танхимаас илгээж буй мэдээллийг холбогдох ажилтнууддаа танилцуулах, хүргэх, дамжуулах;

- 5.10 Бусад гишүүддээ зах зээлээ өргөжүүлэх, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхэд нь туршлагаа хуваалцах, арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх, харилцан бие биеэ дэмжих, хөнгөлөлт урамшуулал үзүүлэх;
- 5.11 Танхимтай шууд харилцах, мэдээлэл солилцох ажилтантай байх, Салбар танхим, гишүүнчлэлийн албатай эргэх холбоотой ажиллах;

ЗУРГАА. ГИШҮҮНЧЛЭЛЭЭ ЦУЦЛАХ, СЭРГЭЭХ

- 6.1 Гишүүн нь гишүүнчлэлээс татгалзсан тухай хүсэлтээ албан бичгээр Үндэсний болон Салбар танхимд гаргаснаар гишүүнээс чөлөөлөгдөнө. Энэ тохиолдолд гишүүнчлэлийн хураамжийг буцаан олгохгүй.
- 6.2 Гишүүн нь 2 жил дараалан гишүүний хураамжаа төлөөгүй тохиолдолд МҮХАҮТ-ын дүрмийн 4.2.6-4.2.10-д заасан үүргээ биелүүлээгүй хэмээн үзэж цахим хаягаар эсхүл утсаар холбогдож сануулна. Ийнхүү сануулснаас хойш 30 хоногийн хугацаанд эрхээ баталгаажуулаагүй бол гишүүнчлэлээс цуцална.
- 6.3 Танхимын гишүүн дараах зөрчлүүдийг гаргасан тохиолдолд гишүүнчлэлээс цуцална. Үүнд:
- Танхимын нэрийн дор хууль бус, өөрт олгогдоогүй эрхийг ашиглаж аливаа үйлдэл хийх
 - Мэргэжлийн болон ёс зүйн дутагдал гаргаж, танхимын нэр хүндэд хохирол учруулах
- 6.4 Гишүүн нь тодорхой шалтгаанаар Улсын бүртгэлээс хасагдсан тохиолдолд гишүүнчлэлээс цуцална.
- 6.5 Гишүүнчлэл нь цуцлагдсан гишүүд өөрийн хүсэлтээр ангиллаа сонгон хураамжаа төлж, гишүүнчлэлээ сэргээх боломжтой.

ДОЛОО. БУСАД

- 7.1 Энэхүү журам нь Салбар танхим болон гадаад дахь төлөөлөгчийн газарт ижил түвшинд үйлчилнэ.
- 7.2 Журамд Гүйцэтгэх захирлын тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулж болно.